

**Ким Жон Рэ "Их шуурганаар сийлэгдсэн түүх:  
Нүүдэлчдийн тухай өгүүлэх нь" номын  
тухай**

Ахлах багш Д.Энхцэцэг

"Мянган жилийн түүхэн хүн" /1998/ номоороо хэдийнээ бидний танил болсон БНСУ-ын сэтгүүлч Ким Жон Рэ гуай "Их шуурганаар сийлэгдсэн түүх" /2002/ хэмээх бүтээлээрээ дахин бидэнтэй бидэнтэй номын өглөг хайрлан золголоо.

Хүн төрөлхтөн гурав дахь мянган жилийн босгоор хэдийнээ алхаж, нийгэм түүхийн асар их хурдацтай хөгжил дэвшилд өртөөлөн дэвшиж, урьд өмнө төсөөлж ч байгаагүй өөрчлөлт, шинэ шинэ нээлтүүд нүд ирмэхийн зуур гарсаар... Энэ хурдаар явах аваас XXI зууны дунд үед дэлхийн хүн ам 8 тэрбумаас хол давж, тэдний олонхи нь 5 саяас илүү хүн амтай томоохон хотод суух болж, их хотын нүргээнт амьдрал, шавхагдашгүй оюун ухаан, мөнхийн хүсэл мөрөөдөл хүнийг өөрийг нь цаг хугацаатай уралдах, яаран довтолох туйлын бухимдал, хийсвэр сэтгэхүй рүү түлхэж, амьдралын язгуур олон шинж алдагдаж, "ирээдүйн шок" гэгчид автагдахад хүргэх ажээ.

Энэ бүхнээс гаргах арга зам байна уу? Байвал ямар арга байна вэ? Тэр нүргээнтэй соёл иргэншлээс огт өөр, тэдний "мөрөөдлийн ертөнц", тэдний төсөөлж байгаагүй, хаанаас ч эрээд олдошгүй, үзэж сонсоогүй өвөрмөц сонин тэр орчин ахуй нь "тал нутаг" нүүдэлчдийн ахуй болохыг хүн төрөлхтөнд таниулахыг зохиогч нэг гол зорилго болгон бичжээ.

Тэр "дигитал эрин үеийнхний мөрөөдлийн ертөнц" нь миний нутаг, бидний монгол орон болох тухай, монгол ахуйн тухай, монголчууд бидний бүтээсэн гайхамшигт түүхийн тухай, зуун зуун мянган жил өнгөрсөн ч монгол монголоороо үлдсэн тухай бахдан шагшран бичжээ. Монгол хүн би эдгээр мөрүүдийг унших бүр, үнэхээр л тийм дээ, үүнийг ингэж хэлж, ингэж л илэрхийллээ дээ, манай ард түмний түүхийг бидний тухай "харийн хүн" яаж ингэж нүдэнд үзэгдэж, сэтгэлд буухуйц бичив гэж өөрийн эрхгүй бахархах сэтгэл төрлөө.

Орчин үед ийм өвөрмөц бичлэг, энгийн мөртлөө яруу өгүүлэмж илэрхийллээр түүхийг бичих нь олон түмэнд илүү их хүртээмжтэй, чихэнд сонсголонтой сонирхолтой болохыг хэлэх юун.

Ким Жон Рэ-гуай өөрийн зохиолд юуны өмнө, монгол орны байгал, цаг уурын тухай, тэр хатуу ширүүн цаг улиралд нүүдэлчин монголчууд хэрхэн зохицож ирсэн тухай, нүүдлийн мал аж ахуй, хүн байгалийн зохицлын тухай, байгал өөрөө монгол хүнийг хатуужуулж, хад чулуу мэт бат бэх, гал дөл мэт халуун эрч хүчтэй болгодог тухай, байгалын бэрхшээл бүхнийг сөрж амьдрах нь тэдний "мөхөшгүй мөнх" байхын үндэс болох тухай зэрэг олон сонирхолтой зүйлийг гярхай ажиглан тэмдэглэжээ.

Монголчууд монголоороо үлдсэн нууц нь нүүдлийн амьдрал, ахуй, хязгааргүй уудам тал нутагтаа "Дүүлэн давхих" "морьтон монголчууд" маргаашийнхаа төлөө эмээлтэйгээ хадагдаж, морин дээр хорвоог элээж ... /23-р тал/ явсантай холбоотой гэжээ.

"Их шуурганаар сийлэгдсэн түүх" номын хэсэг нь, нүүдэлчин монголчуудын түүхийг өгүүлэх агаад энэ сонин түүхийг зөвхөн хүүрнэн өгүүлэх зорилгоор бичсэн бус, хамгийн гол нь түүхийн нугалаанд нуугдсан, аажим аажмаар ил гарч буй хойшид хүн төрөлхтөнд гарцаагүй хэрэг болох ...нүүдэлчдийн соёл иргэншлийн мөнхийн мөн чанарыг олж нээн уншигчдад хүртээл болгоход чиглэгджээ.

Зохиолч, юуны өмнө, монгол нутагт хүн суух болсон нэн эртний үед нүүдлийн соёл иргэншлийн үндэс тавигдсан болон Төв Ази дахь анхны төр улс Хүннүгийн түүхийг бичихдээ Хан улсын түүхч Сыма Цяны "Түүхийн тэмдэглэл", Грегийн түүхч Геродот, Фукидидийн түүхээс аваад монголын болон дэлхийн түүхнээ холбогдох олон тооны сурвалж, бүтээлүүдийг нягтлан үзсэн нь судлаачийн нөр их шаргуу хөдөлмөрч төрхийг харуулж байна.

Египетийн пирамид, Вавилоны цамхагтай адил дэлхийн гайхамшигт зүйлсийн нэг болох Хятадын их цагаан хэрмийг юуны учир, хэрхэн босгох болсноос аваад Хүннү гүрний удам угсаа, хүчирхэгжин мандсан түүх, алдарт хаад Атиллагийн түүхийг ч бичиж, Хятадын цагаан хэрмээс Ромын эзэнт улс хүртэлх бүс нутгийн түүхэнд нүүдэлчид ямар их нөлөөтэй байсныг, тэдний үлдээсэн ул мөр өнөөдөр ч мянга, мянган жилийг алгасан оршсоор байгааг өгүүлжээ.

“Нүүдэлчдийн тухай өгүүлэх нь” номын дараагийн хэсэг нь “Их Монгол улс”, “Монголын эзэнт гүрний” түүхэнд холбогдох юм. Дэлхийн түүхэнд “Монголчуудын хэмээх” бүхэл бүтэн хоёр зууны түүх нь, нэг талаар “монголчуудын хоорондын эв нэгдэл, бат цул”-тай холбоотой. Энэ их нэгдлийг “Тал нутгийн од” VIII бүлэг/ их эзэн Чингис хаантай салшгүй хүйн холбоотой болохыг Ким Жон Рэ гуай тэмдэглээд, “тэнгэрт гэрэлтэх од мэт мэт түүнд бүгд хайртай байжээ” гэжээ.

Тэр үед тал нутгийн нүүдэлчид эзэн хаанаа дагаж, “Дүүлэн давхих” морин довтолгооноор дэлхийд шинэ дэг жаяг тогтоон, өөрсдийнх нь өмнө сөгдөх суурьшмал ертөнцийг харж, суурин амьдралын үхээнц түгжигдмэл байдлыг мэдэрч, наран мандахаас жаргах хүртэл уудам их нутаг миний газар шороо гэж их хаан нь зарлиг буулгаж явжээ. Тэгж явахдаа тэд жаргалтай байсан. Шинэ түүхийг эзэн хаантайгаа бичилцэж амьдралынх нь утга учир улам бүр үнэ цэнээ олсныг ойлгох болсноор гуниг харамсалгүй морьтойгоо довтолгосоор байсан ажгуу ... иймээс ямагт нүүдэлчдийн ялалт байсан юм” гэж бидний бахархах дуртай найман зууны тэртээх буурал түүхийн тухай олонтой магтсан нь сэтгэл хөдлөхгүй байхын аргагүй.

Үнэхээр тэр л цагт монголчууд манай гариг ертөнцийн энэ эрин үеийн хүсэл мөрөөдөл “Даяаршлын” эх үндсийг тавьж юу ч үл нэвтрэх хэрмэлж цайзалсан соёл иргэншлийн бүрдлүүдийн хоорондын хаалт саадыг арилгасан болохыг зохиогч “Монгол туургатны эрин үе” гээд “мянган жилийн турш бие биедээ мөнхийн харшилж байсан өрнө, дорно өөр хоорондоо хандах сэтгэхүйг өөрчлөхөд тэд хувь нэмрээ оруулсан юм” гэж тэмдэглэжээ.

Сүр хүчээ гайхуулсан Чингисийн эзэнт гүрэн байгуулагдсанаас 170 гаруй жил, Чингис хааны таалал төгссөнөөс 150 гаруй жилийн дараа мөхөв... гэх боловч, энэ нь ердийн нэгэн улсын доройтон буурах, өөдөлж уруудах үеийг тодорхойлсон утгатай адил “мөхөл” байсангүй. Ямар ч атугай Чингис хааны улс мөхсөн удаагүй ...

“... Хашаа хэрэм барин суугчид мөхөж нутаг сэлгэн нүүдэллэгчид үл мөхмөй” гэж зохиогч номынхоо төгсгөлд бичсэн нь өнөө болтол монголын нүүдэлчдийн соёл иргэншил оршсон хэвээр бөгөөд “монгол туургатан эрин үеэс” зөвхөн тэдэнд төдийгүй, дэлхийн олон улс түмэнд өвлөгдөж үлдсэн олон зүйлс байгаа нь бахархууштай зэрэг олон асуудлыг хөнджээ.

Ким Жон Рэ гуайн нөр их хөдөлмөр шингэсэн энэхүү бүтээл монголын түүхийн судалгаанд чухал хувь нэмэр болох нь дамжиггүй билээ.

Мөн, бидний тухай, гайхамшигтай сайхан сэтгэгдэл төрүүлэм, өөрсдийн түүхээр бахархахгүй байх аргагүй энэ сайхан номыг нутаг нэгтнийхээ оюуны мэлмийд толилуулсан орчуулагч, эрдэмтэн Б.Лхагва танд гүн талархал илэрхийлье!

Номын хур арвин байх болтугай.